


АШИГТ МАЛТМАЛЫН Тусгай зөвшөөрлийн Сонгон шалгаруулалтад Оролцогчдын

ГАРЫН АВЛАГА



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

Энэхүү “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын зорилго нь Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

<https://mrbam.gov.mn/public/pages/19/Tushaal-Songon.pdf>

Уул уурхайн үндэсний үйлдвэрийн сайдын
2018 оны 47 дугаар тушаалын хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Ашигт малтмалын тухай хуульд заасан үндэслэлээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх) олгох сонгон шалгаруулалтыг зохион явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сонгон шалгаруулалтыг шударга, ил тод, нээлттэй өрсөлдөх тэгш боломжоор хангах, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан олон нийтийн хяналтын дор явуулна.
- 1.3. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2 дахь хэсэгт тусгасан хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогод нийцүүлэн сонгон шалгаруулалтыг зохион явуулна.
- 1.4. Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил заагт хамаарсан талбайд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “Төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газарт уламжлан шийдвэрлүүлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, нийтэд мэдээлэх

- 2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Төрийн захиргааны байгууллага” гэх)-ын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулна.
- 2.2. Төрийн захиргааны байгууллага нь Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т зааснаар аймаг, Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 2.3. Засгийн газар нь Төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтооно.
- 2.4. Төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон талбайн солбицлыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг гаргах, түүнийг бүртгэх

- 3.1. *Сонгон шалгаруулалтын бэлтгэл хангах*
 - 3.1.1. Төрийн захиргааны байгууллагын Кадастрын асуудал хариуцсан нэгж нь Засгийн газраас тогтоосон талбайгаас Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5, 17.6, 17.7-д заасан шаардлагыг хангасан талбайг тухай бүр ялгаж, талбай тус бүрээр багц мэдээллийг бэлтгэх ажлыг хариуцна.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

/“Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын гуравдугаар зүйлийн 3.2-т заасны дагуу/

Засгийн газраас баталсан талбайгаас Төрийн захиргааны төв байгууллага/Уул уурхай хүнд үйлдвэрийн яам/-ын сонгосон сонгон шалгаруулалт явуулах талбайд Төрийн захиргааны байгууллага/Ашигт малтмал газрын тосны газар/ нь сонгон шалгаруулалт явуулахаар урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр /байгууллагын албан ёсны вебсайт/ нийтэд зарлан мэдээлнэ.

Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгасан байна.

Сонгон шалгаруулалтын талбайн байршил, талбайн нэр;

Талбайн солбицол;

Талбайн хэмжээ /гектараар/;

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг ирүүлэх хаяг, хүлээн авах албан тушаалтан, холбогдох утасны дугаар;

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа;

Сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн саналыг нээх хугацаа, газар;

Сонгон шалгаруулалтын босго үнэ, түүнийг байршуулах дансны дугаар;

Сонгон шалгаруулалтын багц мэдээллийг авах газрын хаяг, үйлчилгээний хураамж, дансны дугаар.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа нь журмын 3.2.1-т заасны дагуу сонгон шалгаруулалтын урилга үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэгдсэнээс хойш хуанлийн 30 (гуч) хоногоос доошгүй байна.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

/“Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын гуравдугаар зүйлийн 3.3.2-т заасны дагуу/

Сонгон шалгаруулалтын материалыг Сонгон шалгаруулалтын журмын 3.3.1-д заасан “сонгон шалгаруулалтад оролцох тухай хүсэлт”/оролцогч аж ахуйн нэгжийн албан ёсны бланкан дээрх албан бичиг/-ийн хамт материал хүлээн авч буй мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

Сонгон шалгаруулалтын санал нь битүүмжилсэн эх хувь болон хуулбар хувь гэсэн 2 хувь байх бөгөөд тус тусад нь битүүмжлэн ирүүлнэ. /эх болон хуулбар хувиудыг 1 хавтсанд хийж болохгүй/

Сонгон шалгаруулалтын материалын хавтасны гадна талын зүүн дээд буланд:

Оролцогч хуулийн этгээдийн нэр:

Шуудангийн хаяг:

Цахим шуудангийн хаяг:

Холбоо барих утас:

Сонгон шалгаруулалт зарласан талбайн байршил: Талбайн код, аймаг сум:

Талбайн нэр:

Сонгон шалгаруулалтын материалын хуудасны тоо /Хуудас/:

Эх болон хуулбар хувийн аль нь болохыг тодорхойлж бичнэ.

Нэр: **“КОМПАНИ” ХХК**
Хаяг: **шуудан, байршил**
И-мэйл: **идэвхитэй ажилладаг**
Утас: **холбогдох боломжтой**
Талбайн код, нэр
Аймаг, сум
Хуудасны тоо: **үнэн зөв**
ЭХ ХУВЬ/ХУУЛБАР ХУВЬ
(аль нэгийг нь бичнэ)



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

/“Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын гуравдугаар зүйлийн 3.3.2-т заасны дагуу/

Сонгон шалгаруулалтын материал дотор “Үнийн санал”-ыг битүүмжлэн дугтуйнд хийж онгойх хэсэгт хуулийн этгээдийн тамга дарж битүүмжилсэн байх, мөн хаягласан байх. Үүнд:

Оролцогч хуулийн этгээдийн нэр:

Талбайн байршил: Талбайн код, аймаг сум, талбайн нэр



ҮНИЙН САНАЛ
Аж ахуйн нэгжийн нэр: “КОМПАНИ” ХХК
Сонгон шалгаруулалт зарласан талбайн байршил:
⇒Код: СШ-ХХ-УУ
⇒Аймаг:
⇒Сум:
⇒Талбайн нэр:

Журмын 3.7, 3.8, 4.2.2-т заасны дагуу сонгон шалгаруулалтын саналын материал хүлээлгэн өгөх, техникийн болон үнийн санал нээхэд оролцох компанийн гүйцэтгэх захирал нь компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй болохоо нотолсон бичиг баримт /нотариатаар гэрчлүүлсэн компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, өөрийн иргэний үнэмлэхний хамт/, хэрэв компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцох бол Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлага хангасан итгэмжлэл, өөрийн иргэний үнэмлэхийг авч ирнэ.

Журмын 3.5, 3.6-д заасан шаардлага хангасан саналыг сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичиг хүлээн авна

Хэрэв шаардлага хангаагүй саналыг нарийн бичиг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд татгалзсан шалтгаан, он сар өдөр цаг минутыг тэмдэглэсэн тодорхойлолтыг ирүүлсэн хүсэлтийн хамт буцаан өгнө

Сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаа дуусмагц комиссын нарийн бичгийн дарга санал хүлээн авах ажиллагааг дуусгаж ирүүлсэн нийт саналыг сонгон шалгаруулалтын комиссын даргад акт үйлдэн хүлээлгэн өгнө

Сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаа дуусах үед бүртгэж байсан саналыг бүртгэж дуусгаад бүртгэлийг шууд хаах бөгөөд бусад дугаарлаж байгаа хуулийн этгээдүүдийн саналыг бүртгэхгүй.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН САНАЛЫГ НЭЭХ

Сонгон шалгаруулалтын техникийн саналыг нээх хугацааг сонгон шалгаруулалтын урилгад зааж өгнө.

Сонгон шалгаруулалт нээх ажиллагаанд оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг заавал байлцуулна. /Захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нээлтэд ирээгүй тохиолдолд уг саналыг нээхгүй бөгөөд оролцогчид журамд заасны дагуу буцааж хүргүүлнэ/

Ирүүлсэн санал нь журмын 3.3.2, 3.4-т заасан шаардлагыг хангахгүй бол энэ тухай тэмдэглэл үйлдэн оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид буцаан өгнө.

Сонгон шалгаруулалтын саналыг Төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу бүрдүүлж, хуудас тус бүрийг нүүрний арын хуудаснаас эхлэн гараар биш тоон дардасаар хуудас тус бүрийг алгасалгүй дугаарласан байна. Хэрвээ дугаарлалт алдагдсан болон засвар хийгдсэн байвал саналыг хүчингүйд тооцон үнэлэхээс татгалзана.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНИЙН САНАЛ НЭЭХ

Сонгон шалгаруулалт нээх үед үнийн саналын битүүмжлэлийг шалгана, битүүмжлэлгүй бол материалыг оролцогчийн гүйцэтгэх захирал эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчид буцаан өгнө.

Сонгон шалгаруулалтын үнийн санал нь журмын 3.3.3-т заасан буюу батлагдсан маягтын дагуу тоо болон үсгээр зөрүүгүй үйлдсэн байх ба энэ шаардлагыг хангахгүй бол 0 (тэг) оноо өгнө.

Сонгон шалгаруулалтад оролцогч нь үнийн саналдаа босго үнийг оруулж тооцно.

Сонгон шалгаруулалтад оролцогчид хүсэлт гаргавал бусад оролцогчийн үнийн саналтай танилцах хүсэлт гаргаж болно.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГ ЗАРЛАХ

Сонгон шалгаруулалтын дүнг баталгаажуулсан АМГТГ-ын даргын тушаалын дагуу шалгарсан оролцогчид үнийн санал болон босго үнийн зөрүү мөн тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг төлөх тухай тухай мэдэгдлийг бичгээр гаргаж хүргүүлнэ.

Сонгон шалгаруулалтад шалгараагүй бусад оролцогчид шалгараагүй үндэслэлийг дурдсан мэдэгдлийг бичгээр гаргаж хүргүүлнэ.

Дээрхи мэдэгдлийг ирж авах тухай оролцогчдод тэдний ирүүлсэн сонгон шалгаруулалтын материалын хавтасанд тэмдэглэсэн утас болон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсний дагуу ирж аваагүй тохиолдолд шуудангийн хаягаар хүргүүлнэ. Оролцогчдын сонгон шалгаруулалтын материалын хавтасан дээрхи хаяг буруугаас шуудан хүргэгдэлгүй буцаж ирсэн тохиолдолд хариуцлагын оролцогч өөрөө хүлээнэ.

АНХААРАХ ЗҮЙЛС

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэд хавсаргасан баримт бичиг нь энэхүү журмын 3.3.1-д заасан шаардлагыг хангаагүй, баримтаар нотлогдоогүй, холбогдох байгууллагаас олгосон хуулийн этгээдийн болон татварын албаны тодорхойлолт, боловсролын үнэмлэх, гэрчилгээ, тоног төхөөрөмжийн гэрчилгээ зэрэг сонгон шалгаруулалтын бичиг баримтыг дуурайлган хийсэн, эсхүл сонгон шалгаруулалтад оролцох зорилгоор тэдгээр бичиг баримтад засвар, өөрчлөлт оруулсан нь илэрхий байвал сонгон шалгаруулалтын комисс үнэлгээ хийхээс татгалзаж, энэ тухай хурлын тэмдэглэлд тусгана.

Тухайн сонгон шалгаруулалтад оролцогч нь хэт өндөр үнийн саналыг /бусад оролцогчдын үнийн саналаас 50-иас дээш хувиар их/ ирүүлсэн боловч төлөхөөс татгалзвал тухайн оролцогчийг энэ журмаар зохицуулагдаж байгаа сонгон шалгаруулалтад дахин оролцуулахгүй.

Сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн санал нь албан ёсны тооцоо, судалгаан дээр суурилсан, хэрэгжих боломжтой, бодитой ажил, үйлчилгээг төлөвлөсөн эсэхийг харгалзан техникийн саналыг үнэлнэ.

Журмын 4.6.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой тухай мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрлийг авах боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсхүл сонгон шалгаруулалтын үнийн санал, босго үнийн зөрүү, эхний жилийн төлбөрийг төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага нь журмын 4.6.5-д заасан мэдэгдлийг хүчингүй болгож, хүсэлт гаргасан хуулийн этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн талбайн сонгон шалгаруулалтад удаах өндөр оноо авсан оролцогчийг шалгарсанд тооцно.

Хэрэв тухайн талбайн сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан оролцогч нь сонгон шалгаруулалтын үнийн саналд тусгасан мөнгөн дүнг энэхүү журмын 4.6.5-д заасны дагуу төлөөгүй бол тус оролцогчийн босго үнийг улсын төеөвт оруулж, буцаан олгохгүй.

Сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчийн техникийн саналд тусгасан хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх, түүнийг хайгуулын ажлын жилийн Таиланд тайлагнасан эсэхэд Төрийн захиргааны байгууллага хяналт тавьж Ашигт малтмалын тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажилллана.